



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 574

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.3, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн Гашуун сухайт дахь хилийн боомтын өргөтгөл шинэчлэлийн ажилтай холбогдуулан ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Гашуунсухайт дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртөө нөхсөн 3 нэрийн, нийт 51,041,700.00 (тавин нэгэн сая дөчин нэгэн мянга долоон зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Гашуун сухайт дахь Гаалийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Ганбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах ажлыг зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Барилга буулгаж, чөлөөлсөн газрыг байгууллагын мэдэлд хэвээр үлдээж зориулалтаар нь ашиглах, нөхөн сэргээх;

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Доржсүрэн

Д.НАРАНГЭРЭЛ

132001496

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 12
дугаар сарын 02-ны өдрийн 575
дугаар тогтоолын хавсралт

Гаалийн Ерөнхий газрын харьяа Гашуун сухайт дахь Гаалийн газрын
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлах үндсэн хөрөнгийн жагсаалт

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын, Хуримтлагдсан элэгдэл дүн (төгрөгөөр)
1	Боомтын үзлэгийн тавцан	2008	ш	1	50,204,000.00	50,204,000.00
2	Хяналт шалгалтын үзлэгийн тавцан	2008	ш	1	276,800.00	276,800.00
3	Нохойн сургалтын байр	2008	ш	1	560,900.00	560,900.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН				3 (гурав)		51,041,700.00 (тавин нэгэн сая дөчин нэгэн мянга долоон зуун)